



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Дорноговь аймгийн Их хэт сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДГА-2019/43/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn
Дорноговь аймаг , Сайншанд сум
2019 он

Тэргүүлэх аудитор: Ч.Ариунаа
Утас: 99092469 Цахим хаяг:
Аудитын менежер: Э.Энхцэцэг
Утас: 90077079 Цахим хаяг:
Аудитор: Э.Батчимэг
Утас: 99032916 Цахим хаяг:


Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

Агуулга

1	Аудитын гэрчилгээ	3
2	Аудитын тайлан	5
2.1	Оршил	5
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	6
2.4	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	6
2.5	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	7
2.6	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	7
2.7	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	8
2.8	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	8
2.9	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	9
2.10	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	9
2.11	Шилэн дансны мэдээлэл	9
2.12	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	10
2.13	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	10
3	Менежментийн захидал	11
4	Аудит хийсэн санхүүгийн тайлан	14

1 Аудитын гэрчилгээ

 ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР 44103 Дорноговь аймаг, Сайншанд сум, 3 дугаар баг, Орон нутгийн өмчийн III байр, Утас: (705) 2-27-34	ДОРНОГОВЬ АЙМГИЙН ИХ ХЭТ СУМЫН ХҮҮХДИЙН ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ Г.ГЭРЭЛТУЯА ТАНАА
2019.02.26 № 4-6/200	
Танай _____ -ны № _____ -т	
Аудитын гэрчилгээ	
<p>Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Их хэт сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.</p>	
Хязгаарлалттай санал дүгнэлт	
<p>Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийг үнэлж, Дорноговь аймгийн Их хэт сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлээгүй гэж дүгнэн хязгаарлалттай санал дүгнэлт гаргаж байна.</p>	
Санал дүгнэлтийн үндэслэл	
<p>Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.</p>	
<p>Аудитаар Дорноговь аймгийн Их хэт сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.</p>	
<p>Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.</p>	
	

Аудитын гол асуудал

2018 оны жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө буюу хуульд заасан хугацаанд бараа материалын тооллого хийж тайлан тэнцэлд тусгаагүй байна.


Энэ зөрчлүүд нь санхүүгийн тайлангийн толилуулга ба илчлэл үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байгаагаас гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2-д "хөрөнгө , төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ", 12 дугаар зүйлийн 12.1.1-д "жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө" гэсэн заалтууд , Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 2-д "Эд хөрөнгийн дотоодын тооллогыг төрийн өмчит хуулийн этгээдийн захиргаа эрхлэн дор дурдсан хугацаанд явуулж улирал , жилийн тайлан тэнцэлд тусгаж тайлагнана" , 70 дугаар зүйлийн 2.2-д "түүхий эд , материал , түлш , сэлбэг хэрэгсэл , бэлэн бүтээгдэхүүн , бараа , сав , баглаа боодлын тооллогыг жилд 2 удаа /6 дугаар сарын 1 , 12 дугаар сарын 1-нээс/" гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Үүрэг, хариуцлага

Дорноговь аймгийн Их хэт сумын Хүүхдийн цэцэрлэг нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.АРИУНАА

2 Аудитын тайлан

2.1. Оршил

Дорноговь аймгийн Их хэт сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Эрхлэгч Г.Гэрэлтуяа-д танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Их хэт сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорноговь аймгийн Их хэт сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 2 дугаар сарын 18-наас 2019 оны 2 дугаар сарын 19-ны өдрийн хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 2 дугаар сарын 19-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Дорноговь аймаг дахь төрийн аудитын газар хариуцаж хэрэгжүүлэв.

Их хэт сумын Хүүхдийн цэцэрлэг 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорноговь аймаг дахь төрийн аудитын газарт 2019 оны 2 дугаар сарын 18-ны өдөр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Дорноговь аймгийн Их хэт сумын Хүүхдийн цэцэрлэгийн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Их хэт сумын Хүүхдийн цэцэрлэг нь СӨБ-ын үйлчилгээний шинэ арга хэлбэрийг дэмжих замаар хүүхэд бүрийг зохион байгуулалттай сургалт, хөгжүүлэх үйл ажиллагаанд тогтмол хамруулж, бага насны хүүхдийг хөгжүүлэх ажлын чанарыг сайжруулна гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

Дорноговь аймгийн Их хэт сумын Хүүхдийн цэцэрлэгийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Сургуулийн өмнөх насныханд анхан шатны боловсрол олгох үйл ажиллагаа

Дорноговь аймгийн Их хэт сумын Хүүхдийн цэцэрлэгийн үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Дорноговь аймгийн Их хэт сумын Хүүхдийн цэцэрлэгийн удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хууль
- Боловсролын тухай хууль
- Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гарсан эсэх талаар дараах заалтад тэмдэглэв.

Байгууллагын үйл ажиллагааг зохицуулж байгаа эрх зүйн орчинд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гараагүй байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Дорноговь аймгийн Их хэт сумын Хүүхдийн цэцэрлэгийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн түвэгтэй байдлыг үнэлэхэд мэргэжилтэн шаардлагагүй буюу мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Их хэт сумын Хүүхдийн цэцэрлэг санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Санхүүгийн тооцоолох групп” ХХК-ийн Acolous” програм хангамж ашигладаг байна.

Дорноговь аймгийн Их хэт сумын Хүүхдийн цэцэрлэг дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд Бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт Үр нөлөөтэй гэж үзлээ.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Дорноговь аймгийн Иххэт сумын Хүүхдийн цэцэрлэгийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 10 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 4 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр Нийт зардлын 0.2 хувиар сонгов.

Нийт зардлыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь батлагдсан төсвийн дагуу зардлыг санхүүжүүлж байгаа тул үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүнгээс материаллаг байдлын түвшинг тогтоосонтой холбоотой юм.

Дорноговь аймгийн Их хэт сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2018 оны Нийт зардал 258,298.2 мянган төгрөг бөгөөд түүний 0.2 хувь болох 518.15 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 0.2 хувиар тооцсон нь нэг удаагийн ажил гүйлгээний дүнтэй холбоотой юм.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 6 чиглэлээр аудитын 10 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 6 асуудлыг алдаа, зөрчилтөйд тооцож, 4 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэснээс гадна аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийгээгүй.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй
асуудлыг ангилсан байдал

(Мянган төгрөгөөр)

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	6	28,093.80	
2	Төлбөрийн акт тогтоосон	0	0.00	
3	Албан шаардлага өгсөн	0	0.00	
4	Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн	0	0.00	
5	Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн	0	0.00	
	Дүн	6	28,093.80	

2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Дараагийн аудитаар анхаарал татахуйц бусад чухал асуудал байхгүй

2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Дорноговь аймгийн Их хэт сумын Хүүхдийн цэцэрлэгийн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 2018 онд 252,915.5 мянган төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 252,915.5 мянган төгрөг буюу 100 хувьтай төсвийн зардлын хэтрэлт хэмнэлт гараагүй байна.

2.11. Шилэн дансны мэдээлэл

Их хэт сумын Хүүхдийн цэцэрлэг Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт 2018 оны жилийн эцсийн байдлаар буюу өмнөх оны аудитаар зөвлөмж өгөгдөөгүй байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Дорноговь аймгийн Их хэт сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Дорноговь аймгийн Их хэт сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Дорноговь аймгийн Их хэт сумын Хүүхдийн цэцэрлэгийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. 2018.12.31-ний байдлаар авлага 121979 төгрөгийн , өглөг 222232 төгрөгийн тус тус үлдэгдэлтэй байна
2. 2018 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар Татварын хэлтсээс 92960 төгрөгийн авлагын үлдэгдэлтэй байна
3. Хууль тогтоомжийн дагуу Хөдөлмөрийн чадвар түр алдалтын тэтгэмж авч байгаа ажилчдад тэтгэмжийг олгохдоо ХХОАТ гэж 10%-г суутган дутуу олгосон байна. Тухайлбал 2018.02.26-нд Жаахантуяа 9341,6 төгрөг , 2018.03.27-нд Нармандахад 3854,1 төгрөг , 2018.04.24-нд Соёлмаад 6852,3 төгрөг , 2018.05.25-нд Хатантөмөрт 12814,2 төгрөг 2018.05.30-нд Хатантөмөрт 12814,2 төгрөг , 2018.09.18-нд Хатантөмөрт 12814 төгрөг , 2018.02.25-нд Хатантөмөрт 12814 төгрөг тус тус дутуу олгосон байна
4. Нийгмийн даатгалын тайлангаар 342753,52 төгрөгийн авлагын үлдэгдэлтэй боловч тооцоо нийлж санхүүгийн тайланд тусгаагүй байна.
5. 2018 оны жилийн эцсээр хөрөнгийн тооллого хийж үлдэгдлийг баталгаажуулаагүй байна
6. Манаач нарт шөнийн цаг бодогддоггүй бөгөөд илүү цагийн хөлсийг байгууллагын хамтын гэрээнд нөхөн амруулаагүй тохиолдолд үндсэн цалинг 1,8 дахин нэмэгдүүлж олгохоор заасан боловч 1,5 дахин нэмэгдүүлж бодсон байна

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2019 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

3.1 Балансын данстай холбоотой асуудал

3.1.1 Илрүүлэлт:

2018.12.31-ний байдлаар авлага 121979 төгрөгийн өглөг 222232 төгрөгийн тус тус үлдэгдэлтэй байна

Энэ нь эрх ба үүрэг батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Төсвийн тухай хууль тус тус зөрчсөн байна.

3.1.2 Эрсдэл:

авлага өглөгийг барагдуулж ажиллаагүй байх

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хуулийн 6.4.8 , 39.4.2 , 45.2 заалтуудыг мөрдөж ажиллах

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Тооцоо нийлж баталгаажуулсан байгаа

3.2 Балансын данстай холбоотой асуудал

3.2.1 Илрүүлэлт:

2018 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар Татварын хэлтсээс 92960 төгрөгийн авлагын үлдэгдэлтэй байна

Энэ нь эрх ба үүрэг батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Төсвийн тухай хууль тус тус зөрчсөн байна.

3.2.2 Эрсдэл:

Санхүүгийн тайлан, тодруулгад тусгасан авлага, өр төлбөрийн үлдэгдлийг харилцагч байгууллагаар хүлээн зөвшөөрүүлж баталгаажуулаагүй байх

3.2.3 Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хуулийн 6.4.8 , 39.4.2 , 45.2 заалтуудыг мөрдөж ажиллах

3.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Тооцоо нийлж баталгаажуулсан

3.3 Тухайн байгууллага, салбартай холбоотой хууль эрх зүйн орчин

3.3.1 Илрүүлэлт:

Хууль тогтоомжийн дагуу Хөдөлмөрийн чадвар түр алдалтын тэтгэмж авч байгаа ажилчдад тэтгэмжийг олгохдоо ХХОАТ гэж 10%-г суутган дутуу олгосон байна. Тухайлбал 2018.02.26-нд Жаахантуяа 9341,6 төгрөг , 2018.03.27-нд Нармандахад 3854,1 төгрөг , 2018.04.24-нд Соёлмаад 6852,3 төгрөг , 2018.05.25-нд Хатантөмөрт 12814,2 төгрөг 2018.05.30-нд Хатантөмөрт 12814,2 төгрөг , 2018.09.18-нд Хатантөмөрт 12814 төгрөг , 2018.02.25-нд Хатантөмөрт 12814 төгрөг тус тус дутуу олгосон байна

Энэ нь эрх ба үүрэг , үнэн зөв байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр тэтгэмжийн тухай хууль , Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийг тус тус зөрчсөн байна.

3.3.2 Эрсдэл:

Хууль журмын хэрэгжилтийг хангаагүй байх

3.3.3 Өгсөн зөвлөмж:

Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 16.1.1 "хууль тогтоомжид тусгайлан заасны дагуу олгож байгаа тэтгэвэр , тэтгэмж , төлбөр , үзүүлж байгаа хөнгөлөлт , нөхөх олговор болон нэг удаагийн буцалтгүй тусламж"-г албан татвараас чөлөөлөх тул заалтыг мөрдөж ажиллах

3.3.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Хариу өгөөгүй

3.4 Балансын данстай холбоотой асуудал

3.4.1 Илрүүлэлт:

Нийгмийн даатгалын тайлангаар 342753,52 төгрөгийн авлагын үлдэгдэлтэй боловч тооцоо нийлж санхүүгийн тайланд тусгаагүй байна.

Энэ нь эрх ба үүрэг , үнэн зөв байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль тус тус зөрчсөн байна.

3.4.2 Эрсдэл:

Санхүүгийн тайланд авлага, өглөг дутуу бүртгэсэн байх

3.4.3 Өгсөн зөвлөмж:

НД-н тайлангийн үлдэгдэл буруу гарч байгаа тул холбогдох залруулгыг харьяалах Нийгмийн даатгалын байгууллагад хийлгэж үлдэгдлийг тулгах

3.4.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

НД-н тайлангаар буруу үлдэгдэл гарч байгаа тул залруулж өгнө гэсэн 2018 онд тооцоо нийлсэн байгаа

3.5 Балансын данстай холбоотой асуудал

3.5.1 Илрүүлэлт:

2018 оны жилийн эцсээр хөрөнгийн тооллого хийж үлдэгдлийг баталгаажуулаагүй байна

Энэ нь эрх ба үүрэг , үнэн зөв байх , иж бүрэн байдал батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль , Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийг тус тус зөрчсөн байна.

3.5.2 Эрсдэл:

Хөрөнгө биетээр байгаа эсэх

3.5.3 Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12.2 " хөрөнгө өр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ" , 12.2.1 "жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө" гэсэн заалтууд , Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70-р зүйлд заасан заалтыг мөрдөж ажиллах нь зүйтэй

3.5.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Хөрөнгийн дахин үнэлгээ хийх болсон тул 9-р сард тооллого хийсэн

3.6 Зардлын данстай холбоотой асуудал

3.6.1 Илрүүлэлт:

Манаач нарт шөнийн цаг бодогддоггүй бөгөөд илүү цагийн хөлсийг байгууллагын хамтын гэрээнд нөхөн амруулаагүй тохиолдолд үндсэн цалинг 1,8 дахин нэмэгдүүлж олгохоор заасан боловч 1,5 дахин нэмэгдүүлж бодсон байна

Энэ нь эрх ба үүрэг , үнэн зөв байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Байгууллагын захиргаа ҮЭ-н хэлэлцээрээр байгуулсан Хамтын гэрээг тус тус зөрчсөн байна.

3.6.2 Эрсдэл:

Цалин, НДШ болон ХХОАТ-ыг зөрүүтэй тооцсон байх

3.6.3 Өгсөн зөвлөмж:

Байгууллагын захиргаа, ҮЭ-н гишүүдийн төлөөллийн хооронд байгуулсан хамтын гэрээний заалтыг мөрдөж ажиллах нь зүйтэй

3.6.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Хариу өгөөгүй

4 Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

СТ-1А

АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	29,575,109.81	30,897,358.81
33	АВЛАГА		121,979.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага		29,019.00
335	Бусад авлага		92,960.00
3351	Байгууллагаас авах авлага		92,960.00
35	БАРАА МАТЕРИАЛ	26,075,109.81	27,275,379.81
354	Хангамжийн материал	26,075,109.81	27,275,379.81
35410	Бичиг хэргийн материал	537,240.00	805,880.00
35420	Аж ахуйн материал	25,462,629.81	22,828,131.81
35440	Түлш, шатах тослох материал	75,240.00	
35460	Хүнсний материал		3,641,368.00
36	НӨӨЦИЙН БАРАА	3,500,000.00	3,500,000.00
36600	Бусад нөөц	3,500,000.00	3,500,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	114,989,947.00	285,424,603.58
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	114,989,947.00	285,424,603.58
392	Биет хөрөнгө	114,989,947.00	275,554,603.58
39201	Барилга, байгууламж, орон сууц	191,668,056.00	262,342,280.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(90,309,526.01)	
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	18,082,069.00	17,587,069.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(16,715,485.99)	(15,894,285.83)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	28,403,083.30	28,011,132.86
39208	Хуримтлагдсан элэгдэл	(18,830,368.30)	(19,321,378.11)
39217	Ном	2,692,119.00	2,829,785.66
393	Биет бус хөрөнгө		9,870,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө		9,870,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III-I+II	144,565,056.81	316,321,962.39
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	1,161,592.17	222,232.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	1,161,592.17	222,232.00
413	Өглөг	1,161,592.17	222,232.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	1,156,592.17	100,253.00
4136	Бусад өглөг	5,000.00	121,979.00
41361	Байгууллагад төлөх өглөг	2,000.00	
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	3,000.00	121,979.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	143,403,464.64	316,099,730.39
51	Засгийн газрын хувь оролцоо	143,403,464.64	316,099,730.39
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	135,311,979.92	145,181,979.92
51101	Өмч: - төрийн	135,311,979.92	145,181,979.92
512	Хуримтлагдсан үр дүн	3,060,200.95	70,508,847.01
51210	Өмнөх үеийн үр дүн	3,060,200.95	3,786,389.19
51220	Тайлант үеийн үр дүн		66,722,457.82
51230	Давхардсан гүйлгээг цэвэрлэх данс		
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	5,031,283.77	100,408,903.46
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI-IV+V	144,565,056.81	316,321,962.39

4417144353
EICA0058 9025701

Дорноговь аймгийн Их хэт сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

СТ-2А

АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Давсны код	Үзүүлэлт	/Төгрөгөөр/	
		Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	134,590,500.00	325,795,698.66
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО		72,880,198.66
120	Нийтлэг татварын бус орлого		72,880,198.66
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого		72,880,198.66
1200045	Үнэ төлбөргүй хулээн авсан орлого		72,880,198.66
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	134,590,500.00	252,915,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	160,000.00	
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	160,000.00	
1330	Төсвийн захирагчдаас	134,430,500.00	252,915,500.00
133001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	134,430,500.00	252,915,500.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	125,556,594.30	258,298,240.67
21	УРСГАЛ ЗАРДАЛ	125,556,594.30	258,298,240.67
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	125,556,594.30	244,939,140.84
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	67,737,809.00	128,977,899.00
210101	Үндсэн цалин	67,283,088.00	123,576,850.00
210102	Нэмэгдэл		341,817.00
210104	Урамшуулал	454,721.00	5,059,232.00
2102	Ажлал олгогчоос нийгмийн даатгалд төлөх шямтгэл	7,663,521.00	15,226,855.00
210201	Тэтгэврийн даатгал	4,956,837.00	10,362,735.00
210202	Тэтгэмжийн даатгал	589,849.00	1,243,349.00
210203	ҮОМШО-ний даатгал	655,146.00	1,015,189.00
210204	Ажилгүйдлийн даатгал	132,879.00	238,240.00
210205	Эрүүл мэндийн даатгал	1,328,810.00	2,367,342.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	33,864,463.00	55,443,431.00
210301	Гэрэл, цахилгаан	2,735,214.00	4,472,999.00
210302	Түлш, халаалт	28,228,992.00	49,400,736.00
210303	Цэвэр, бохир ус	2,900,257.00	1,569,696.00
2104	Хангамж, бараа материалын зардал	1,134,200.00	11,481,618.00
210401	Бичиг хэрэг	416,300.00	1,434,360.00
210402	Тээвэр, шатахуун	494,900.00	976,840.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	43,000.00	47,720.00
210404	Ном, хэвлэл		72,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	180,000.00	2,891,100.00
210408	Бараа материал ахталсны зардал		6,059,598.00
2105	Нормативт зардал	11,017,342.00	25,329,888.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	15,812.00	297,566.00
210502	Хоол, хүнс	11,001,530.00	25,032,322.00
2107	Томьлолт, зочны зардал	84,000.00	694,000.00
210702	Дотоод албан томилолт	84,000.00	694,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	235,000.00	398,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	235,000.00	398,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,820,259.30	7,387,449.84
210902	Хичээл үйлдвэрлэлийн даллага хийх	11,000.00	11,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	3,809,259.30	7,376,449.84
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		13,359,099.83
2132	Бусад урсгал шилжүүлэг		12,701,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг		12,381,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		320,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг		658,099.83
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг		658,099.83
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	9,033,905.70	67,497,457.99
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	775,000.17
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	775,000.17
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	(775,000.17)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	9,033,905.70	66,722,457.82

4417144353
ЕНОА0056 902570

Дорноговь аймгийн Их хэт сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

СТ-3А

АУДИТ ХИЙГДСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Дансны код	Үзүүлэлт	/Төгрөгөөр/	
		Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	134,590,500.00	252,915,500.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	134,590,500.00	252,915,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	160,000.00	
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	160,000.00	
1330	Төсвийн захирагчдаас	134,430,500.00	252,915,500.00
133001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	134,430,500.00	252,915,500.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	106,563,182.00	252,915,500.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	106,563,182.00	252,915,500.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	106,563,182.00	239,556,400.17
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	59,379,500.00	130,137,093.17
210101	Үндсэн цалин	52,084,000.00	113,905,193.17
210102	Нэмэгдэл	3,092,200.00	6,184,000.00
210104	Урамшуулал	4,203,300.00	10,047,900.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	6,863,100.00	15,126,600.00
210201	Тэтгэврийн даатгал	6,863,100.00	10,190,300.00
210202	Тэтгэмжийн даатгал	-	1,077,500.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	-	1,191,100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	-	242,500.00
210205	Эрүүл мэндийн даатгал	-	2,425,200.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	30,648,940.00	55,443,431.00
210301	Гэрэл, цахилгаан	2,735,214.00	4,472,999.00
210302	Түлш, халаалт	25,130,148.00	49,400,736.00
210303	Цэвэр, бохир ус	2,783,578.00	1,569,696.00
2104	Хангамж, бараа материалын зардал	443,000.00	5,778,620.00
210401	Бичиг хэрэг	30,000.00	910,500.00
210402	Тээвэр, шатахуун	370,000.00	901,600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	43,000.00	60,220.00
210404	Ном, хэвлэл	-	199,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	3,707,300.00
2105	Нормативт зардал	8,460,042.00	30,259,256.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	15,812.00	297,566.00
210502	Хоол, хүнс	8,444,230.00	28,673,690.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	1,288,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	180,000.00	763,500.00
210604	Урсгал засвар	180,000.00	763,500.00
2107	Томилдолт, зочны зардал	60,000.00	691,400.00
210702	Дотоод албан томилолт	60,000.00	691,400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	235,000.00	379,500.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	235,000.00	379,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	293,600.00	977,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн даллага хийх	293,600.00	977,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	13,359,099.83
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	12,701,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	12,381,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	320,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	658,099.83
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	658,099.83
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	28,027,318.00	-
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-	-
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	28,027,318.00	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	28,027,318.00	-

4417144353
ЕЮА0056 9025707

СТ-4А

АУДИТ ХИЙГДСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/ таграгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	135,311,979.92	5,031,283.77	(5,973,704.75)	*	134,369,558.94
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	135,311,979.92	5,031,283.77	(5,973,704.75)		134,369,558.94
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт					
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт					
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					
C07	Тайлант үеийн үр дүн			9,033,905.70		9,033,905.70
C08	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	135,311,979.92	5,031,283.77	3,060,200.95		143,403,464.64
D01	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	135,311,979.92	5,031,283.77	3,060,200.95		143,403,464.64
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			726,188.24		726,188.24
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	135,311,979.92	5,031,283.77	3,786,389.19		144,129,652.88
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт		95,377,619.69			95,377,619.69
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт					
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					
D07	Галваад валютын хөрвүүлэлтийн зөрүү					
D08	Тайлант үеийн үр дүн	9,870,000.00		66,722,457.82		76,592,457.82
D09	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	145,181,979.92	100,408,903.46	70,508,847.01		316,099,730.39

4417144353
EHOA0056 9025707

Дорноговь аймгийн Их хэт сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

П

АУДИТ ХИЙГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		/ төгрөгөөр /	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	252,915,500.00	252,915,500.00		100.0%
21	УРСГАЛ ЗАРДАЛ	252,915,500.00	252,915,500.00		100.0%
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	240,214,500.00	239,556,400.17	658,099.83	99.7%
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	130,529,300.00	130,137,093.17	392,206.83	99.7%
210101	Үндсэн цалин	113,696,100.00	113,905,193.17	(209,093.17)	100.2%
210102	Нэмэгдэл	6,184,000.00	6,184,000.00		100.0%
210104	Урамшуулал	10,649,200.00	10,047,900.00	601,300.00	94.4%
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	15,126,600.00	15,126,600.00		100.0%
210201	Тэтгэврийн даатгал	10,276,000.00	10,190,300.00	85,700.00	99.2%
210202	Тэтгэмжийн даатгал	991,800.00	1,077,500.00	(85,700.00)	108.6%
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,191,100.00	1,191,100.00		100.0%
210204	Ажилгүйдлийн даатгал	242,500.00	242,500.00		100.0%
210205	Эрүүл мэндийн даатгал	2,425,200.00	2,425,200.00		100.0%
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	55,563,000.00	55,443,431.00	119,569.00	99.8%
210301	Гэрэл, цахилгаан	4,604,900.00	4,472,999.00	131,901.00	97.1%
210302	Тууш, халаалт	49,400,700.00	49,400,736.00	(36.00)	100.0%
210303	Цэвэр, бохир ус	1,557,400.00	1,569,696.00	(12,296.00)	100.8%
2104	Хангамж, бараа материалын зардал	5,822,000.00	5,778,620.00	43,380.00	99.3%
210401	Бичиг хэрэг	910,500.00	910,500.00		100.0%
210402	Тээвэр, шатахуун	924,200.00	901,600.00	22,600.00	97.6%
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	70,000.00	60,220.00	9,780.00	86.0%
210404	Ном, хэвлэл	190,000.00	199,000.00	(9,000.00)	104.7%
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,727,300.00	3,707,300.00	20,000.00	99.5%
2105	Нормативт зардал	30,264,900.00	30,259,256.00	5,644.00	100.0%
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	303,200.00	297,566.00	5,634.00	98.1%
210502	Хоол, хувс	28,673,700.00	28,673,690.00	10.00	100.0%
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,288,000.00	1,288,000.00		100.0%
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	776,000.00	763,500.00	12,500.00	98.4%
210604	Урсгал засвар	776,000.00	763,500.00	12,500.00	98.4%
2107	Томилголт, зочны зардал	726,000.00	691,400.00	34,600.00	95.2%
210702	Дотоод албан томилолт	726,000.00	691,400.00	34,600.00	95.2%
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	405,700.00	379,500.00	26,200.00	93.5%
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	405,700.00	379,500.00	26,200.00	93.5%
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	100,100.00	97,700.00	2,400.00	97.6%
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,001,000.00	977,000.00	24,000.00	97.6%
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	12,701,000.00	13,359,099.83	(658,099.83)	105.2%
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг				
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг				
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг				
2132	Бусад урсгал шилжүүлэг	12,701,000.00	12,701,000.00		100.0%
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	12,381,000.00	12,381,000.00		100.0%
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	320,000.00	320,000.00		100.0%
	Олгосон санхүүжилт шилжүүлэг		658,099.83	(658,099.83)	
	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг		658,099.83	(658,099.83)	
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	16	16		100.0%
620001	Удирдах ажилтан	1	1		100.0%
620002	Гүйцэтгэх ажилтан	8	8		100.0%
620003	Үйлчлэх ажилтан	7	7		100.0%
620004	Гэрээт ажилтан				
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)				
630	ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД				
631	СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА				
632	МЭРГЭЖЛИЙН СУРГАЛТ, ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТӨВ				
64	ЭМЧЛҮҮЛЭГСЭДИЙН ТОО				
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ				

4417144353
ЕЮА0056 9025707